



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар A/13

Мөрөн сум

Салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь Хэлний бодлогын салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Гишүүд:

Х.Цэнд-Аюуш	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
Б.Базардамбуу	(Аймгийн Статистикийн хэлтсийн дарга)
П.Галсандорж	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Г.Ням-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч)
Б.Түвшинсүх	(Ерөнхий боловсролын "Титэм" сургуулийн менежер)
Б.Алимаа	(Ерөнхий боловсролын "Сод Эрдэм" сургуулийн багш)
Б.Чинзориг	(Ерөнхий боловсролын "Эрдмийн далай" сургуулийн багш)
Д.Лхамсүрэн	(Ерөнхий боловсролын "Дэлгэрмөрөн цогцолбор" сургуулийн багш)
П.Мөнгөнбаясгалан	(Ерөнхий боловсролын "Ирээдүй ХХI зуун" сургуулийн багш)

Нарийн бичгийн дарга:

О.Нямгэрэл (Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын Монгол хэл, уран зохиолын мэргэжилтэн)

2. Салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөг гаргаж батлуулахыг нарийн бичгийн дарга (О.Нямгэрэл)-д даалгасугай.

3. Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмыг мөрдөж ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Зөвлөл байгуулах тухай" А/13 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010041